



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

991 оны 10 сарын 22 өдөр

Дугаар А/Ч/03.

Мандалтова

Албан тушаалын тодорхойлолт  
батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.4, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2021 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн 168 дугаар тогтоол, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 03 дугаар тогтоолоор батлагдсан "Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам"-ын 5.1, Төрийн албаны зөвлөлийн "Зөвшөөрөл олгох тухай" 2021 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 232 дугаар тогтоолыг тус тус үндэслэн  
**ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Аймгийн Засаг даргын эрхлэх хүрээний хэрэгжүүлэгч агентлаг Соёлын хэлтсийн даргын албан тушаалын тодорхойлолтыг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан албан тушаалын тодорхойлолтыг соёлын хэлтсийн даргын үйл ажиллагаанд мөрдүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Л.Доржбат), Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (А.Нарантуяа) нарт үүрэг болгосугай.



481210567

Дундговь аймгийн Засаг даргын 2021 оны  
... дугаар сарын ...-ний өдрийн ... дугаар  
захирамжийн хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан  
шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр,  
огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг  
баталсан огноо:

Байгууллагын нэр:

Нэгжийн нэр:

Дундговь аймгийн Соёлын хэлтэс

Албан тушаалын нэр:

Албан тушаалын ангилал,  
зэрэглэл:

Дундговь аймгийн Соёлын хэлтсийн  
дарга

ТЗ-10

Ажлын цаг:

Ажлын байрны албан ёсны  
байршил:

Ажлын өдөр 8 цаг

Дундговь аймаг. Дундговь аймаг  
7-р баг

Хөдөлмөрийн нөхцөл:

Онцгой нөхцөл:

Хэвийн

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Соёлын талаарх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжүүлэх,  
холбогдох байгууллага, албан тушаалтныг мэргэжил, арга зүйгээр хангах,  
дэмжлэг үзүүлэх, хэлтсийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион  
байгуулах, хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлж, гүйцэтгэлийн үр дүнг  
аймгийн Засаг даргын өмнө хариуцна.